



МОНГОЛ УЛС  
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 12 сарын 22 өдөр

Дугаар А/831

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн "б", Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын багцаас агаар, орчны бохирдлыг бууруулах санхүүжилтээр "Алтан орд констракшн" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн Гэр хороолол дунд Таунхаус зохион байгуулалттай, цөөн айлын жишиг сууцны төсөл хэрэгжүүлэхэд дэд бүтцийн асуудлыг шийдэх ажлыг хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

Б.Баярсүх

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга

Гишүүд:

Н.Цацралцэцэг

- Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

Х.Баасанхүү

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн мэргэжилтэн

А.Цэен-Ойдов

- Байгаль орчин, аялал жуулчлалын газрын мэргэжилтэн

Д.Эрдэнэбат

- Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан

Zax A/831 Ch

02 4170


- Г.Тунгалаг - Жаргалант сумын Захирагчийн ажлын албаны мэргэжилтэн
- А.Пүрэвдорж -“Ховд цахилгаан түгээх сүлжээ”ХХК-ний ерөнхий инженер
- М.Нансалмаа -“Шим-ус” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын ерөнхий инженер
- Ц.Даваасамбуу -Орон нутгийн өмчийн газрын ахлах мэргэжилтэн
- С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга
- Э.Даваасүрэн - “Алтан орд констракшн” ХХК-ийн гүйцэтгэх захирал

Нарийн бичгийн  
дарга:

- С.Өнөржаргал -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дэд бүтэц хариуцсан мэргэжилтэн

2. “Алтан орд констракшн”ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Б.Баярсүх/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН  
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН